

МОНГОЛ УЛСЫН МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД СУУРИЛСАН ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Удиртгал

2010 онд аймгийн нийт сум, байгууллагаас үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохиосон ажлын тайлан, аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн тухай статистикийн мэдээлэл, зарим сум, агентлагийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан зэрэг суурь мэдээллүүдийг ашиглан Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтын байдал, үр дүнд үнэлгээ хийлээ.

Энэхүү үнэлгээний зорилго нь Нутгийн захиргааны байгууллагуудаас Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, түүний үр дүнд аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд гарсан өөрчлөлтийг тодорхойлох явдал байлаа.

Үнэлгээг Засгийн газрын 2010 оны 95 дугаар тогтоолоор баталсан төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн болно.

2009, 2010 онд орон нутагт Үндэсний хөгжлийн цогц бодлогыг зохион байгуулж хэрэгжүүлэх зорилгоор “Баян-Өлгий аймгийн 2010-2020 оны хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулан хэрэгжүүлж байгаагийн дээр нийт сумд хөгжлийн стратеги, хэтийн төлөвлөгөөтэй болсон. Түүнчлэн бүх шатны Засаг дарга нарын үйл ажиллагааны хөтөлбөр, байгууллагуудын хэтийн болон жилийн төлөвлөгөө, бодлогын баримт бичгүүдэд Үндэсний хөгжлийн цогц бодлогын зорилтуудыг тусгуулж, уялдаа холбоог нь хангах удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авсан.

Эдгээр ажлын үр дүнд орон нутагт аймаг, сум, албан байгууллагын түвшинд үндэсний хөгжлийн цогц бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа уялдуулах боломж бүрдэж, эдийн засаг, нийгмийн хөгжилд ахиц өөрчлөлт гарсан байна.

НЭГ. Нийгмийн хөгжлийн хүрээнд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт

1. Ядуурал ажилгүйдлийг бууруулах бодлогын хэрэгжилт

а/ Зохион байгуулсан ажил: *Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах асуудлыг нутгийн захиргааны бүх шатны байгууллагын үйл ажиллагааны тэргүүлэх зорилт болгон дэвшүүлсэн.

*Ажилгүй, ядуу иргэд, ялангуяа нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах шаардлагатай иргэдийг сум, баг бүрээр нарийвчлан бүртгэж, тэднийг дэс дараатайгаар ажилтай болгох, хоршоо, нөхөрлөл бүлэг байгуулах санаачилгын дэмжих ажил, амьжиргааны эх үүсвэртэй болгох арга хэмжээ авсан.

*Ажил олгогч эздийн зөвлөлгөөнийг зохион байгуулж, ажлын байр нэмэгдүүлэх, нэн ядуу иргэдэд туслах хөдөлгөөн өрнүүлсэн.

*Хамгийн олон ажлын байр буй болгосон аж ахуйн нэгж байгууллага шалгаруулах уралдаан зарлаж дүгнэдэг.

*Ажилгүй иргэдийн дунд мэргэжил олгох сургалт зохион байгуулсан.

*Ажилгүй иргэдийг хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрт хамруулсан.

б/ Үр дүн: 2010 онд аймгийн хэмжээнд шинээр 1800 ажилтан орлоготой болсон. Нийт 198 аж ахуйн нэгж байгууллага, иргэнд 1,4 төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосноор 51 жижиг дунд үйлдвэр байгуулагдаж, 320 хүн ажлын байртай болсон. Мөн 395 өрхөд 50.0 сая төгрөгийн хүүгүй зээл олгож 611 хүнд мэргэжил олгосон.

Ядуурал ажилгүйдлийг бууруулах талаар зохион байгуулсан ажлын хамгийн гол үр дүн бол иргэдэд зах зээлийн харилцааны нөхцөлд бие дааж ажиллаж амьдрах сэтгэлгээ төлөвшиж байгаа явдал юм.

2. Боловсролын хөгжлийн бодлогын хэрэгжилтийн талаар

а/ Зохион байгуулсан ажил: *Боловсролын салбар, сургалтын орчин нөхцөлийг цаашид сайжруулах, багш нарын ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 2009 онд 600,0 сая, 2010 онд 540,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.

* Өлгий, Сагсай сумдад бага сургуулийн барилга шинээр баригдсан.

* Алтай, Буянт зэрэг 4 сумын сургууль спортын шинэ танхимтай болсон.

* Алтай, Сагсай, Алтанцөгц сум болон Шүвтэр, Улаанхад багийн сургуулийн өргөтгөл, Хүүхдийн 8 цэцэрлэгийн их засвар хийгдсэн.

* ЕБС-иудад 579 компьютер нийлүүлсэн.

* ЕБС-ийн багш нарыг чадваржуулах зорилгоор багш нарын сонгон шалгаруулалтыг зохион байгуулдаг болсон.

* ЕБС-иудыг аттестатчилсан.

б/ Үр дүн: *2010 онд аймгийн хэмжээнд 2000 гаруй сурагчийн суралцах, амьдрах орчин сайжирсан.

* Мэргэжилтэй багш нарын хангалт 99,3 хувьд хүрсэн.

* Аймгийн хэмжээнд ерөнхий шалгалтын дундаж оноо 27,6 пунктээр өссөн.

* Иргэд, эцэг эхчүүдийн боловсролын ач холбогдлыг үнэлэх үнэлэмж дээшилж, сургууль завсардалт буурсан.

3. Эрүүл мэндийн хөгжлийн бодлогын хэрэгжилт

а/ Зохион байгуулсан ажил: *Аймгийн эрүүл мэндийн хөгжлийн стратеги төлөвлөгөөг боловруулсан.

*Аймаг, сум, өрхийн эмнэлгийн ажлын нөхцөл, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах, эмч мэргэжилтнүүдийг чадваржуулах зорилгоор эрүүл мэндийн салбарт 2009 онд 570,0, 2010 онд өмнөх оныхоос 3 дахин их буюу 1,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.

*2010 онд Алтай, Баяннуур, Булган, Ногооннуур сумдад тус бүр 15-20 ортой хүн эмнэлгийн барилгыг шинээр барьсан.

*Төв, хөдөөгийн эмнэлгүүдэд түргэн тусламжийн туулах чадвар сайтай 9 автомашин, 20 багийн эмчид мотоцикль олгосон.

*Аймгийн Нэгдсэн эмнэлгийг Улаанбаатар хот дахь ЭНЭШ төв, Улсын клиникийн III эмнэлэг, Хавдар судлалын үндэсний төвтэй алсын зайны оношлогооны сүлжээнд холбосон.

*2009 онд 150, 2010 онд 126 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадваржуулах сургалтанд хамруулсан, энэ оноос Норвеги улсын тусламжийн байгууллагын дэмжлэгтэйгээр эмч, мэргэжилтнүүдийн чадавхийг дээшлүүлэх төсөл хэрэгжүүлж эхэлсэн.

*Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгааг чиглэсэн зорилготой, системтэй болгосон.

*Хүн ардын эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн үндэсний хэмжээний “Халдварт өвчинтэй тэмцэх”, “Халдварт бус өвчнөөс сэргийлэх”, “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” зэрэг 10 хөтөлбөрийг нутгийн захиргааны хяналтанд авч байнга дэмжлэг үзүүлж байгаа.

* “Эрүүл мэндэд ээлтэй байгууллага”, “Эрүүл мэндэд ээлтэй Засаг дарга” шалгаруулах болзол зарлаж дүгнэдэг.

*Сум, багийн эмч, аймгийн Эрүүл мэндийн газрын даргын хооронд “Эх нярайн эрүүл мэндийг хамгаалах” гурвалсан гэрээ байгуулж дүгнэдэг болсон.

*Хөдөө сум, багт нарийн мэргэжлийн эмч нарын багийг тодорхой хуваариар ажиллуулдаг.

б/ Үр дүн: *2010 онд 0-1 насны нялхасын эндэгдэл өмнөх оныхоос 20,6 промилээр, 1-5 насны хүүхдийнх 8,9 промилээр, эхийн эндэгдэл 44,7 промилээр буурч, сүрьеэ зэрэг халдварт өвчний гаралт багассан.

*Иргэдийн өөрсдийнхөө эрүүл мэндийг хамгаалах, эрүүл аж төрөх эрмэлзэл эрс өссөн.

4. Соёл, урлагийн хөгжлийн бодлогын хэрэгжилт

а/ Зохион байгуулсан ажил: *Урлаг соёлын байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлэхэд анхаарч аймгийн ХД театрт 100,0 сая, соёлын төвүүдэд 110,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, 40,0 сая гаруй төгрөгийн техник аппаратур, хөгжмийн зэмсэг нийлүүлсэн.

*Номын сангийн фондыг 43,2 сая төгрөгийн номоор баяжуулсан.

*Аймгийн номын сангийн барилгыг 2011 онд барихаар эцэслэн шийдвэрлэсэн.

*Аймгийн ХД театрын жүжигчдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь сургалтад хамруулсан.

*ХД театрын жүжигчид хөдөөгийн сумдаар тодорхой хуваарийн дагуу тоглолт хийдэг болсон

б/ Үр дүн: *Иргэд олон нийтийн урлаг соёлын арга хэмжээнд хамрах хүрээ нэмэгдэж, урлаг, соёлын үнэлэмж дээшилсэн.

5. Нийгмийн хөгжлийн бодлогын хэрэгжилт

а/ **Зохион байгуулсан ажил:** *Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, нэгжүүдийг чадваржуулах арга хэмжээ авсан, сургалтанд хамруулж, техник хэрэгслээр хангасан.

*Сум, баг бүр айл өрх, хүн амын талаар мэдээллийн сантай болж, хэнд ямар үйлчилгээ шаардлагатайг нарийвчлан тодорхойлох чадвартай болсон.

*Зах зээлийн эрэлт, иргэдийн хэрэгцээ сонирхолыг судлаж мэргэжил олгох сургалтуудыг зохион байгуулсан.

*Өрх бүрээс нэг иргэнийг ажилтай, орлоготой болгох бодлого боловсруулж хэрэгжүүлж эхэлсэн.

*Аймгийн төвд ахмадын ордон, Толбо суманд ахмадын амралт сувиллын танхим байгуулсан.

*2010 онд аймгийн хэмжээгээр иргэдэд 12,2 тэрбум төгрөгийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн нь 2008 оныхоос 4 дахин их байна.

б/ **Үр дүн:** *Орон нутагт нийгмийн халамжийн үйлчилгээний тогтолцоо бүрдэж, халамж үйлчилгээний тогтолцоо бүрдэж, халамж хүртэгсдийн мэдээллийн сантай болсон.

*Нийгмийн даатгалд хамрагдагсадын хүрээ нэмэгдсэн.

*Мэргэжилтэй ажиллагсдын тоо нэмэгдэж, бүх шатанд ажлын байр буй болгох эрмэлзэл, сонирхол өссөн.

Хоёр. Эдийн засгийн өсөлт, хөгжлийн бодлогын хэрэгжилт

а/ **Зохион байгуулсан ажил:** Үйлдвэр, дэд бүтцийн хөгжилд зориулан 2009 онд 11,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.

*хөдөө аж ахуйн салбарт 2009 онд 1,0 тэрбум, 2010 онд 1,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.

*Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж хөгжүүлэхэд зориулан 2009 онд 763,0 сая, 2010 онд 648,9 сая нийт 1,4 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон.

*Өлгий хотын дулааны хангамж болон цахилгааны шугам сүлжээний шинэчлэлийн ажлыг бүрэн дуусгасан.

*Ховдын Дуут-Өлгийн Булганы чиглэлийн ЦДАШ-ын барилгын ажил дуусах шатандаа орсон.

*Сагсай, Улаанхус суманд томоохон бетон гүүр, Булган, Дэлүүн, Алтай сумдад модон гүүрүүд барьж гол замын чиглэлийн саад бэрхшээлийг арилгасан.

*Өлгий хотын 1,7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй нисэх буудлын хатуу хучилттай зурвасын барилгын ажлын 70 хувийг гүйцэтгэж, 2011 оны 7 дугаар сард ашиглалтанд авах боломжтой болсон.

*Өлгий-Цагааннуурын хатуу хучилттай замд 6,0 тэрбум төгрөгийн ажил хийгдсэн.

*Аймгийн 70 жилийн ой угтсан ажлын хүрээнд 2,4 тэрбум төгрөгийн засвар тохижилтын ажил хийгдсэн.

*Аймгийн ХАА-н салбарыг тогтвортой хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр боловсруулан ИТХ-ын хуралдаанаар батлуулж, хэрэгжүүлэх ажилд орсон.

*Өрхийн газар тариаланг дэмжиж, иргэдийн дунд энэ чиглэлээр сургалт, сурталчилгаа хийсэн, үр бордоо, техник хэрэгслээр хангах, хөнгөлөлттэй зээл олгох боломжоор хангасан.

б/ Үр дүн: *Татварын бааз суурь өргөжиж төвлөрсөн төсвийн болон орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 0,1-5,6 хувиар давж биелэгдсэн.

*Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн өнгөрсөн оныхоос.....хувиар нэмэгдсэн.

*2009-2010 оны өвөл, хаврын зудын гамшгийг хамгийн бага хохиролтойгоор даван туулсан.

*Газар тариаланд усалгаатай талбайн хэмжээ 4,0 мянган га-д хүрч төмс хүнсний ногооны ургац, байгалийн хадлангийн хэмжээ эрс нэмэгдсэн.

*Жижиг, дунд болон өрхийн үйлдвэрлэл эрхлэх боломж нөхцөл сайжирсан.

ГУРАВ. Байгаль орчныг хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын хэрэгжилт

а/ Зохион байгуулсан ажил: *Байгаль орчныг хамгаалах салбарт 2009 онд 58,2 сая, 2010 онд 141,5 сая төгрөгийн хөрөнгө оруулсан.

*Үүлэнд зориудаар нөлөөлж бороо оруулах төхөөрөмжтэй болж үр дүнтэй ажилладаг болсон.

*Мод үржүүлгийн газар байгуулж хамгийн ихээр цөлжиж байгаа газрын судалгааг гаргаж, 190,0 мянган ширхэг улиас, бургасны суулгац үржүүлж, 140,0 га талбайг ойжуулсан.

*Алтай, Дэлүүн, Сагсай, Цэнгэл, Ногооннуур, Бугат сумдад сайн дурын байгаль хамгаалагч 35 нөхөрлөл байгуулсан.

*Байгаль хамгаалах байгууллагын ажилтан, мэргэжилтнүүдийг сургалтанд хамруулж чадавхижуулах арга хэмжээ авсан.

*Аялал жуулчлалын байгалийн болон угсаатны зүйн чиглэлийн маршрут зураглал, сурталчилгааны материал бэлтгэж гадаад, дотоодод сурталчилсан.

*Олон улсын бүргэдчдийн баяр зохион байгуулдаг уламжлалтай болсон.

*Бүргэдээр ан хийх зан үйлийг ЮНЕСКО-д бүртгүүлсэн.

*Иргэдийн хүрээлэн байгаа байгаль орчноо хамгаалах сэтгэлгээ эерэгээр өөрчлөгдөж байгаа.

*Ойжуулсан талбайн хэмжээ нэмэгдсэн.

*Жуулчдын тоо нэмэгдсэн.

Дөрөв.Эрх зүй, төрийн байгууллагын хөгжлийн бодлогын хэрэгжилт

а/ Зохион байгуулсан ажил: *Төрийн албан хаагчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэхэд анхаарч сум, агентлагийн удирдах ажилтнуудыг 100 хувь, бүх шатны төрийн албан хаагчдын дийлэнх олонхийг төв, орон нутгийн болон бүсчилсэн сургалтанд хамруулсан.

*Төрийн захиргааны байгууллагуудын дотоод журам, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг шинэчилсэн.

*Булганаас бусад бүх сумдыг төрийн сангийн сүлжээнд холбосон.

*Иргэний бүртгэл мэдээллийн цахим сантай болсон.

*Төрийн нэрийн өмнөөс иргэдэд үйлчилдэг эрүүл мэнд, боловсрол, мэргэжлийн хяналт, халамжийн үйлчилгээ зэрэг байгууллагуудын нээлттэй хаалганы өдрүүдийг зохион байгуулж үйл ажиллагааных нь тайланг иргэдээр хэлэлцүүлж, үнэлэлтт дүгнэлт өгүүлдэг болсон.

*Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд ХШҮ хийдэг журам бүрэн нэвтэрсэн.

*Хөдөөгийн сумдын ЗДТГ-ыг компьютер, техник хэрэгслээр үе шаттайгаар хангаж байгаа.

б/ Үр дүн: *Нутгийн захиргааны байгууллага, төрийн албан хаагчдын чадавх дээшилсэн.

*Төрийн үйлчилгээний хүртээмж, чанар, соёлд ахиц гарсан.

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗДТГАЗРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ